

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

□ТАХЬКО□ХК-ийн ТУЗөвлөлд

Бид □ТАХЬКО□ХК-ийн (цаашид □Компани□гэх) 2014 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилийн Баланс, Орлого үр дүнгийн тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан болон Мөнгөн гүйлгээний тайлан бүхий санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад аудит хийлээ.

Санхүүгийн тайлангуудтай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага

Удирдлага нь эдгээр санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, шударгаар толилуулах болон заль мэх, алдаанаас үүдэлтэй материаллаг буруу тайлагналаас ангид санхүүгийн тайлан бэлтгэхэд хүрэлцэхүйц дотоод хяналтыг тогтоон ажиллуулах үүрэг хүлээнэ.

Аудиторын үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитын ажилдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргаж та бүхэнд тайлагнах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх болон мэргэжлийн ёс зүйн шаардлагуудыг даган мөрдөхийг биднээс шаарддаг.

Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн мэдээ болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд сууридан сонгодог бөгөөд үүнд, залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдлийн үнэлгээг хийхтэй холбоотойгоор, аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг тодорхойлохын тулд тухайн байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж үнэн зөвөөр илэрхийлэхтэй холбоотой дотоод хяналтыг авч үздэг. Түүнчлэн санхүүгийн тайлагналыг ерөнхийд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцоолууд болон хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын ул үндэстэй бөгөөд тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан.

Бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж үзэж байна.

Аудиторын дүгнэлт

Бидний дүгнэлтээр □ТАХЬКО□ХК-ийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Хороо (НББОУСХ)-ноос гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Бусад асуудал: Энэхүү тайланг Монгол улсын "Компанийн тухай хууль"-ийн 91 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд бодох. "ТАХЬКО"ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Захирал, МНБ

/Д.Товуудорж/

"Мэдээлэл Аудит" ХХК
Улаанбаатар хот, Монгол Улс



Огноо: 2015-02-25